

Тодруулгын дагуу хариу хүргүүлж байна.

Тодруулсан хэсэгт хариу тайлбаруудыг оруулав.

-1- Эдгээр заагдсан давтамж хувиргагчийн заавал энэ үзүүлэлтээр сонгож санал болгох уу, эсвэл танай үйлдвэрийн онцлогт тохируулан хамгийн оновчтой сонголтыг санал болгож болох уу? Хэрэв бид өөрсдийн сонголтыг хийх боломжтой гэж үзвэл дараахи нэмэлт мэдээллийг тодруулж өгнө үү?


Үүнд:


1. Ямар төрлийн ачаалал тэжээгддэг тухайд. Насос, вентилятор, конвейер, тээрэм гэх мэт.

Тайлбар: 250, 315кВт-ийн давтамж хувиргагч нар нь вентиляторын тоног төхөөрөмж дээр суурилуулагдах ба 90 кВт-ийн давтамж хувиргагч нь хэвлэгч төхөөрөмжинд суурилагдана.

2. Давтамж хувиргагч тус бүрээс тэжээгдэх цахилгаан хөдөлгүүрийн пайзны утга ачааллын гүйдэл.

Тайлбар:





3. Суурилуулар ерөөний нөхцөл:

A. Тусгай зориулалтын цахилгаан өрөөн дотор, эсвэл үйлдвэрийн заалан дотор, тоостой, чийгтэй гэх мэт нөлөөл дор байдаг эсэх

Тайлбар: Үйлдвэрийн цахилгаан техникийн өрөөнд суурилагдах ба тоостой орчинд ажиллана.

B. Ямар хамгаалалтын IP зэргийг сонгон авбал тохиромжтой талаар: IP20. IP21. IP42. IP54 гэх мэт

Тайлбар: IP21 юмуу IP42 тохиромжтой.

C. Өрөөний хамгийн дээд болон доод талын температур: Зунд хамгийн дээд тал нь хэдэн градус хүрч халдаг вэ? +40°C-аас дээш халдаг уу?

Тайлбар Орчны температур зундаа +40°C хүртэл халдаг. Өрөө нь албадмал агаар сэлгэлттэй.

D. Далайн түвшинээс дээших өндөржилт: 1350м

Тайлбар: 1300-1350м

4. Давтамж хувиргагчийг алсаас компьютерээс удирдахын тулд цуваа интерфэйсийн нэмэлт модуль шаардлагатай эсэх. ABB брэндийн давтамж хувиргагчид нь RS485 modbus сүлжээний холболт стандарт сонголтоор нийлүүлэгддэг. Үүнээс өөр нэмэлт модуль шаардлагатай бол дурдана уу?

4. PLC siemens S7-300 болон S7-1200.1500 төхөөрөмжүүдтэй холбогдох боломжтой байх. +RS485 Modbus байж болно.

-2- Тендерийн материалд заагдсан давтамж хувиргагчийн талаар:

1. Жагсаалтын 1-2. Халуун агаар сорогч болон хэвлэгчийн цахилгаан хөдөлгүүр тус бүрд 250kw болон 90-110kw чадалтай ABB Acs880-17 маркийн инвертер сонгосон байна. ACS880-17 нь Cabinet-built regenerative drives буюу хөдөлгүүрт үүссэн энергийг сүлжээ рүү өгч ажиллах зориулалттай Давтамж хувиргагч юм. Хэрэв энэ горимд ажиллуулах шаардлагагүй гэвэл энгийн Давтамж хувиргагч сонгон авч болох уу? Суурилуулах орчны нөхцөл, хөдөлгүүрийн пайзны мэдээлэл, IP зэргийг тодруулж өгнө үү?

Тайлбар:

1. 250кВт инвертор ACS880-07 0505A-3 R10 normal current-505 Max current-560 KW-250 kVA-350

2. 90-110кВт инвертэр ACS880-01 206A-3 R7 normal current-206 Max current-560 KW-110

2. Жагсаалтын 3. Уурын зуухны халуун үлээгч дымсод 315kw ABB Inverter Acq 580-34-585A инвертер сонгосон байна. ACQ 580-34 нь "Ultra-low harmonic drive module for water and wastewater" буюу усны насосны тусгай программ хангамжтай гармоникийн ялгаруулалтанд онцгой шаардлага тавигдсан нөхцөлд

сонгогддог хийцтэй давтамж хувиргагч байна. Энд дымососийн хэрэглээнд тохирсон энгийн Давтамж хувиргагч сонгон авч болох уу? Суурилуулах орчны нөхцөл, хөдөлгүүрийн пайзны мэдээлэл, IP зэргийг тодруулж өгнө үү?

Тайлбар:

315кВт инвертэр ACS880-07 0585A-3 R10 normal current-585 Max current-730 KW-315 kVA-405

3. Жагсаалтын 4, 6, 7, 8. Энд Chint болон SAJ брэндийн Inverter-үүдийг сонгосон байна. Эдгээр хэрэглээнд тохирсон өөр брэндийн Давтамж хувиргагчыг дүйцүүлэн сонгон авч болох уу? Суурилуулах орчны нөхцөл, хөдөлгүүрийн пайзны мэдээлэл, IP зэргийг тодруулж өгнө үү?

Тайлбар:

Эдгээр давтамж хувиргагч нь нэг брэнд байж болно SAJ-1000B, ABB ACS880-01 дүйцэхүйц байж болно. Конвейер шнейк гэх мэт төхөөрөмжүүдэд суурилуулагдана. Суурилуулагдах орчны нөхцөл цахилгааны техникийн өрөөнд тоостой орчинд ажиллана.

4. Жагсаалтын 5. Савлагааны орох болон фракцыг гарахын цахилгаан хөдөлгүүрт давтамж хувиргагч биш нарны инвертер сонгосон байна. Энэ хэрэглээнд тохирсон, цахилгаан хөдөлгүүр удирдах зориулалттай энгийн давтамж хувиргагчийг сонгон авч болох уу? Суурилуулах орчны нөхцөл, хөдөлгүүрийн пайзны мэдээлэл, IP зэрэг, ё тодруулж өгнө үү?

Тайлбар:

Энгийн давтамж хувиргагч байж болох ба SAJ-1000B, ABB ACS880-01 дүйцэхүйц тоноглол сонгож болно. Суурилуулагдах орчны нөхцөл цахилгааны техникийн өрөөнд тоостой орчинд ажиллана.

-3- Мөн эдгээр давтамж хувиргагдыг суурилуулах орчны зай талбайн хязгаарлалт байгаа бол тодруулж өгнө үү? Жишээ нь, самбар дотор суудаг бол давтамж хувиргагчийн гадаад оврын хэмжээ [Урт x Өргөн x Өндөр] -ээс хэтрэхгүй байх талаар зааж өгнө үү?

Тайлбар:

250кВт болон 315кВт инверторүүд тусдаа ил суурилуулагдах ба бусад бага чадлын давтамж хувиргагчууд нь 2,1м өндөртэй самбарт суурилуулагдана.